



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/305

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/203 дугаар тушаалын В.1-д заасан Эрсдлийн нөөцөөс "Рио-2016" зуны олимпийн XXXI наадамд оролцох жүдо бөхийн баг тамирчдын бэлтгэлжилтийг хангах эм, витаминжуулалтын зардалд дэмжлэг үзүүлэхэд 50.000.000 /тавин сая/ төгрөгийн төсвийг зарцуулах эрхийг Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн дарга /Д.Жаргалсайхан/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн дарга /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Х.Бакытжан/-д даалгасугай.

САЙД



С.ЛАМБАА

081138